**МОНГОЛ УЛС**
**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 01 өдөр Дугаар А/339 Мөрөн сум

Газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187, 2023 оны А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын саналыг үндэслэн 1 иргэн, 1 аж ахуйн нэгжийн хоёр нэгж талбарт гаргасан хүсэлтийн дагуу нийт 0.1749га (1749м$^2$) газрын газар эзэмшүүлсэн аймаг, сумын Засаг даргын холбогдох захирамжид хавсралтад дурдсанаар газрын зориулалтад өөрчлөлт оруулж, эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэнтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

6712011047 Захирамж2024

Аймгийн Засаг даргын 2024 оны
07 дугаар сарын ..01...-ны өдрийн
А/...339 дугаар захирамжийн хавсралт

## ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ ӨӨРЧЛӨХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

| № | Иргэн, хуулийн этгээдийн овог, нэр, регистр | Нэгж талбарын дугаар | Газрын байршил | Эзэмшиж буй газрын зориулалт | Өөрчилж буй газрын зориулалт | Өөрчлөлт оруулж буй захирамжийн багана | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Батжин овгийн Доржсүрэн Тогтохбаяр (РГ85080912) | 6712008690 | 8-р баг Дамдинбазар-2 212 тоот | Аж ахуйн | Үйлчилгээтэй орон сууц | Аймгийн Засаг даргын 2021.10.19-ний өдрийн А/486 дугаар захирамжийн хавсралтын 12 дахь заалтын 5 дахь багана (1305$м^2$) | Газрын зориулалт өөрчлөх |
| 2 | Хөвсгөл аймгийн бурхан шашинтны төв мөрөнгийн хүрээ гандан даржайлин хийд (РД:8001472) | 6712012650 | 7-р баг Далайван-3 304 тоот | Худалдаа, үйлчилгээ | Орон сууц | Аймгийн Засаг даргын 2014.05.09-ний өдрийн А/190 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтын 12 дахь заалтын 4 дэхь баганын газрын зориулалтыг орон сууцны зориулалттай, 7 дахь баганын газар эзэмших хугацааг 25 жилээр сунгаж өөрчлөлт оруулах (444$м^2$) | Газрын зориулалт өөрчилж, газар эзэмшүүлэх хугацааг сунгах |

Нийт талбайн хэмжээ-1749$м^2$

------------оОо------------